

Дугаар 3 2001 он

## РЕДАКЦИЙН ҮГ

"Монголын Хүн Ам ба Хөгжил" Нийгэмлэг нь хүн ам, хөгжлийн асуудлаар сонирхогч хүмүүсийн хамтын ажиллагааг нэгтгэх, тэдний үйл ажиллагааг уялдуулах, хүн ам, хөгжлийн талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, үндэсний боловсон хүчнийхээ чадавхийг бүрдүүлэх, нэмэгдүүлэх зорилготой Төрийн Бус Байгууллага юм.

НҮБ-ын Хүн Амын Сангийн тусламжтайгаар МУИС-ийн Хүн Ам Зүйн Сургалт Судалгааны Төв нь 1996 оноос эхлэн Монголын хүн амын асуудлуултай холбоотой эрдэм шинжилгээний бүтээлүүдийг нийтийн хүртээл болгох, хүн амын судалгааны салбарт өөрийн орны болон олон улсын эрдэмтэд, судлаачдын бүтээлийг хэвлэн нийтлэх зорилгоор "Монголын Хүн Ам Зүйн Сэтгүүл"-ийн нийт 4 дугаарыг хэвлэн гаргасан билээ.

Сэтгүүлд хэвлэгдэх материалын цар хүрээг нэмэгдүүлэх, чанар, үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор цаашид тус сэтгүүлийг "Монголын Хүн Ам ба Хөгжил" Нийгэмлэг эрхлэн гарах болсон ба та бүхэнд анхныхаа дугаарыг толилуулж байна.

Та бүхэн манай сэтгүүлд өөрийн эрдэм шинжилгээний бүтээлүүдээ хэвлүүлэхийн зэрэгцээ тус сэтгүүлийн талаарх өөрийн санал, хүсэлтээ ирүүлбэл бид гүнээ талархах болно.

Сэтгүүлийн редакци  
2001 оны 9 дүгээр сар